



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/110

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Ховд хотын гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалт /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ш.Нохойжав -Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүдэд: Ц.Даваасамбуу -Орон нутгийн өмчийн газрын
ахлах мэргэжилтэн

Ц.Баяржаргал -Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ц.Батэрдэнэ -Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Х.Дэмид -Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02.00647
D/Tush-A/110-Da